



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/439

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад заасан нийт, 786,817,522.00 (долоон зуун наян зургаан сая найман зуун арван долоон мянга таван зуун хорин хоёр) төгрөгийн үнэ бүхий, 363,683,294.16 (гурван зуун жаран гурван сая зургаан зуун наян гурван мянга хоёр зуун ерэн дөрвөн төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-эрдэнэ), “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Г.Батзориг), Багахангай дүүргийн “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202075



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Суудлын тээврийн хэрэгсэл	Хьюндай Азера	03-57 УБУ	КМНН41ВВ ЕА364111	2014	1	61,700,000.00	61,700,000.00	-	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
2	Бульдозер тусгай зориулалтын	ТҮ230-3	98-61 УН	ZO52206	2018	1	360,773,886.00	171,854,523.92	188,919,362.08	"Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ	Багахангай дүүргийн "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ
3	Бульдозер тусгай зориулалтын	ТҮ230-3	98-62 УН	ZO52205	2018	1	364,343,636.00	189,579,703.92	174,763,932.08		
Нийт дүн							786,817,522.00	423,134,227.84	363,683,294.16		